

Мэдээлэл

Танилцуулга

Энэхүү мэдээлэл нь Сайншанд салхин парк төслийн барилга угсралт болон үйл ажиллагаатай холбогдуулан тус төслийн ойр орчимд газар ашиглаж буй иргэдэд мэдээлэл олгох зорилгоор Сайншанд салхин парк төслийн зүгээс бэлтгэсэн болно. Тус тайлбар бичиг нь зөвхөн мэдээлэл олгох зорилготой.

Сайншанд салхин парк

Сайншанд салхин парк ХХК нь Монгол улсын говийн бүсэд 55 МВт хүчин чадалтай салхин цахилгаан станцыг барьж байгуулан үйл ажиллагааг явуулахаар төлөвлөөд байна. Тус төслийн хүрээнд Улаанбаатар хотоос 486 км болон Сайншанд хотоос зүүн урагш 7,5 км зайд 25 ш салхин турбин суурилуулах бөгөөд тус төслийн үйл ажиллагаа нь 30 жил байх юм. Сайншанд салхин парк төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2009 онд анх батлуулж, 2015 онд дахин боловсруулж батлуулсан. .

Төслийн талбайн нөлөөлөл

Сайншанд салхин парк төслийн газар нь улсын өмч бөгөөд Сайншанд, Алтанширээ болон Өргөн сумаас ашиглах зөвшөөрлөөр авсан. Тус төслийн талбайн ойр орчимд бусдын аюулгүй байдлыг хангах зорилгоор аюулгүй бүсийг тогтоосон. Энэхүү аюулгүйн бүсийг турбиний өндөр, турбиний далбайн хэмжээ мөн турбинээс үүсэх дуу чимээг харгалзан 500м байхаар тогтоосон ба тус зурваст малчдын зуншлага болон өвөлжөө байршлахыг хориглоно. Аюулгүйн бүсийн дүрмийг барилга угсралтын үед болон салхин паркийн үйл ажиллагааны турш дагаж мөрдөнө.

Барилга угсралтын ажил үргэлжлэх 2 жилийн хугацаанд төслийн талбайг бэлчээрийн зорилгоор ашиглахыг хориглоно. Тус хугацаанд төслийн талбайд хүнд машин механизмын хөдөлгөөн их байх учир бусдын аюулгүй байдлыг хангах үүднээс хориглосон болно. Салхин паркийн үйл ажиллагаа эхэлсэний дараа турбиний суурь, дэд станц болон удирдлагын байрны талбайгаас бүсэд хэсэгт мал бэлчих бүрэн боломжтой.

Өнгөрсөн хугацаанд хийгдсэн судалгааны хүрээнд төслийн аюулгүйн бүсэд хоёр айлын өвөлжөө орсон байгааг тогтоосон. Энэ хоёр өвөлжөөг нүүлгэн шилжүүлж газрыг чөлөөлөх шаардлагатай.

Гол зарчим

Сайншанд салхин парк төслийн нүүлгэн шилжүүлэлт болон амжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөөний гол зарчмууд

- Газар ашиглалт нь Монгол улсын болон олон улсын стандартыг дагаж мөрдөнө;
- Нөхөн төлбөр нь нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг бүрэн хамрах бөгөөд газрыг чөлөөлж өгөхөөс өмнө төлөх болно;
- Нөхөн төлбөрийг давуу эрхтэйгээр санал болгоно;

- Нөлөөлөлд орсон өрхийг засаг захиргааны мэдээлэл, талбайн судалгаа болон бусад айл өрхтэй хийсэн ярилцлагын үндсэн дээр тодорхойлсон;
- Зөвхөн тасалбар болгох өдрөөс өмнө бүртгэгдсэн айл өрхөд нөхөн төлбөрийг олгоно;
- Барилга угсралт болон үйл ажиллагааны үед төслийн талбайн хязгаарлалтыг хамгийн бага байлгахаар тооцоолсон;
- Өргөдөл, гомдол хүлээн авах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулсан;
- Нөлөөлөлд орсон иргэдтэй үулзаж зөвшилцсөн;
- Эмзэг бүлгийн иргэдтэй үулзалт хийсэн бөгөөд шаардлагатай нөхцөлд тулалцаа үзүүлэх болно;

Сайншанд салхин парк төслийн газар чөлөөлөх явц

Газар ашиглах эрх авах явц нь дараах дараалалтай байна:

1. Нөлөөлөлд өртсөн айл өрхийг засаг захиргаанаас авсан мэдээлэл болон талбай дээр хийсэн судалгааны үр дүнд тодорхойлно. – Энэ ажил хийгдсэн.
2. 2016 оны 5, 10-р сард нийгэм эдийн засгийн судалгааг хийж гүйцэтгэсэн.
3. Нөлөөлөлд өртсөн айл өрхийн өвөлжөөний эд хөрөнгийн бүртгэлийг хийж (тасалбар болгох өдөр буюу 2016 оны 11-р сарын 30), тухайн айл өрх болон төслийн багтай хамтран баталгаажуулна.
4. Дээрх алхам буюу 3-р алхамд хийгдсэн эд хөрөнгийн бүртгэлийг үндэслэн нөлөөлөлд өртсөн айл өрх тус бүрт нөхөн төлбөр олгох санал боловсруулна. Нөхөн төлбөр олгох зарчим нь бүх айл өрхөд ижил байх боловч эд хөрөнгийн бүртгэлийг үндэслэн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байна.
5. Нөхөн төлбөрийн хэмжээг харилцан тохиролцож, нөхөн төлбөр олгох гэрээнд гарын үсэг зурна.
6. Зуншлага буюу зуслангийн бэлчээр нь нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд нөхөн төлбөр олгоно. Энэхүү нөхөн төлбөр олгогдох өрхүүдийг тодруулах, нөхөн төлбөр олгох үйл явцыг нарийвчлан тодорхойлох ажлыг малчдыг зусландаа буухаас өмнө хийж гүйцэтгэнэ.

Бусад мэдээлэл

Хэрэв та газар чөлөөлөх асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу.

Д.Нандинбаяр

Менежер

Сайншанд Салхин Парк ХХК

Ди Эйч Эл Оффис Байр,

8 давхар, 801 тоот,

Энхтайваны Өргөн чөлөө-10/5,

СБД-1, Улаанбаатар

Имэйл: nandinbayar@euro-khan.com

Утас: 99990416

Санал, гомдол

Хэрэв танд аливаа өргөдөл, гомдол, санал байвал төслийн багт хандана уу. Төслийн багт хандсанаас хойш 14 хоногийн дотор танд хариу өгөн, асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах болно.